



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР



THE WORLD BANK  
IBRD | IDA | WORLD BANK GROUP



SGM  
МОНГОЛ УЛСАД  
ЗАСАГЛАЛЫГ  
БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

# Монгол Улсад “ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТ”-ийн хандлага, үйл ажиллагааны төлөвлөгөө ба цаашдын алхамуудын талаарх ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

| Мэдээлэл солилцох уулзалтад зориулав |

2020.09.15 | Улаанбаатар хот



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР  
САНГИЙН ЯАМ



THE WORLD BANK  
IBRD • IDA | WOR DBANK GROUP



SGM

МОНГОЛ УЛСАД  
ЗАСАГЛАЛЫГ  
БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ


# МОНГОЛ УЛСАД ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ



# ЕРӨНХИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- Төсөв, санхүүгийн сахилга бат, удирдлага, ил тод хариуцлагатай байдлыг бэхжүүлэн сайжруулахад Засгийн газрын үйл ажиллагааг дэмжих зорилготой Европын Холбоо (ЕХ) болон Дэлхийн Банкны хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад Засаглалыг бэхжүүлэх төсөл” (цаашид “Төсөл” гэх)-ийг ЕХ-ны санхүүжилтээр 2018/2019 оноос эхлэн хэрэгжүүлж байна.
- Энэхүү төслийн хүрээнд **Төрийн санхүүгийн удирдлага (ТСУ)**-ын шинэчлэлийн Монгол дахь өнөөгийн нөхцөл байдал болон **ЖМТ-ийн чиглэлээр хийгдэж буй анхдагч уулзалтуудын үеэр гол оролцогч талуудаас авсан мэдээлэл** (2020 оны 1-р сарын 20-ноос 30-ны өдрүүдэд);
- Олон улсын Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт (ЖМТ)-ийн зөвлөх хатагтай Александра Владисавлевич (Aleksandra Vladisavjevic)-ийн санал болгож буй Монгол Улсад ЖМТ-ийн туршин нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө.

# ЖМТ-ИЙН АЖЛЫН ХЭСЭГ



- ЖМТ-ийг нэвтрүүлэх чиглэлээр “САНГИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСҮВДЛЫН ХҮРЭЭНД ХАМРАГДАХ БАЙГУУЛЛАГА, АГЕНТЛАГИЙН ЖЕНДЭРИЙН СТРАТЕГИ (2016-2024)” батлагдан хэрэгжиж байна.
- “Сангийн сайдын болон зарим төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн үйл явцыг үе шаттайгаар жендэрийн мэдрэмжтэй болгох” **3 дахь зорилтын** хүрээнд төлөвлөгдсөн үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлэх
- Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд жендерийн дүн шинжилгээ хийх, ЖМТ-ийг салбарын яамдад үе шаттай туршин нэвтрүүлэх чиг үүрэг бүхий **“АЖЛЫН ХЭСЭГ”**-ийг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн А-88 дугаар тушаалаар байгуулсан.

ЖМТ-ийг боловсруулахдаа байгууллага дотроо удирдан чиглүүлэх, хүлээгдэж буй үүрэг, оролцоог таниулах, хариуцах эзэнтэй байлгах анхнаас нь чухал ач холбогдолтой ба мөн түүнчлэн ЖМТ-ийг ТСҮ-д оруулахад үр дүнтэй уялдаа холбоо шаарддаг тул энэхүү Ажлын хэсгийг ЖМТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу байгуулсан.

- Сангийн яам (СЯ);
- СЯ, ЖҮХ, ҮСХ болон төсвийн захирагчдын хооронд;
- Бусад холбогдох оролцогч талуудтай.

# АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД



## САНГИЙН ЯАМНААС:

### Дарга:

- Г.ЗОЛБОО (ТБТГ-ын Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга)

### Гишүүд:

- Т.БАТСҮХ (ТБТГ-ын Төсвийн зарлагын хэлтсийн Ахлах зөвлөх)
- П.БАТ-ЭРДЭНЭ (ТБТГ-ын ТЗХ-ийн *Боловсролын салбар хариуцсан төсвийн мэргэжилтэн*)
- Э.НОМИН-ЭРДЭНЭ (ТБТГ-ын ТЗХ-ийн *Хөдөлмөр эрхлэлтийн салбар хариуцсан төсвийн мэргэжилтэн*)

### Нарийн бичгийн дарга

- Х.БӨРТЖИН (ТБТГ-ын ТЗХ-ийн зөвлөх)

## БУСАД ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС:

### Гишүүд: /зөвшилцсөнөөр/

- Ю.АЛТАНТУЯА (БСШҮСЯ-ны СБТГ-ын ахлах шинжээч)
- О.НОРЖМАА (ХНХЯ-ны ХЭБХЗГ-ын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ хариуцсан ахлах мэргэжилтэн)
- П.БОЛОРМАА (ХНХЯ-ны МБСБХЗГ-ын Хөдөлмөрийн зах зээл, элсэлт, төгсөлт, статистик мэдээ хариуцсан мэргэжилтэн)
- Т.ОЮУНСҮРЭН (ҮСХ-ны ХАНГ-ын статистигч)
- О.БУЯНАА (ЖҮХ-ны АА-ны салбар дундын бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)
- Э.ЭРДЭНЭЦЭЦЭГ (Дэлхийн банкны ЖМТ-ийн дотоодын зөвлөх)
- Г.ПҮРЭВТОГТОХ (ЖМТ-ийн шинжээч)
- В.ДАНААСҮРЭН (Үдирдлагын академийн багш)
- Б.ОНОН (ЖК-ын тэргүүн, жендерийн үндэсний шинжээч)

# МОНГОЛ УЛСАД ЖМТ-ИЙН ХАНДЛАГА, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БА ЦААШДЫН АЛХАМУУДЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:

2020 оны 6 дугаар сард дахин шинэчилсэн.

Энэхүү санал болгож буй ЖМТ-ийн хандлага, үйл ажиллагааны төлөвлөгөөг Дэлхийн банкны ЖМТ-ийн Олон улсын зөвлөх Александра Владисавлевичийн СЯ, ЖҮХ болон бусад оролцогч талуудтай зөвлөлдсөний үр дүнд 2020 оны 1-р сард боловсруулж, танилцуулсан.

# ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАНИЛЦУУЛГА

- Төслийн хүрээнд ЖМТ-ийн чиглэлээр хийгдэж буй анхдагч уулзалтуудын үеэр гол харилцагч талуудаас авсан мэдээлэл (2020 оны 1-р сарын 20-30);
- Жендэрийн эрх тэгш байдлыг дээшлүүлэх чиг үүргийг Хууль болон Стратегиар тогтоож өгсөн. Жишээ нь: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө.
- ЖМТ-ийг нэвтрүүлэх тухай Сангийн яамнаас баталсан Дунд хугацааны Жендэрийн Стратеги 2016-2024-д тусгасан.
- Өнөөдрийг хүртэл ЖМТ-ийг нэвтрүүлэх хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд туршлага судлах аялал, сургалт, арга хандлагын эхний алхмууд болон боломжит арга зүйн хүрээ зэрэг багтана.
- Төрийн санхүүгийн удирдлагын шинэчлэлийн Монгол дахь өнөөгийн нөхцөл байдал: 2019 оноос ЖМТ-ийн үйл явцыг Төсвийн цаглабар болон төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналын бүх үе шатуудыг хамарсан, ХСТ-ийн чиглэлийн ТСҮ-ын шинэчлэлд нягт уялдсан байдлаар дахин эхлүүлсэн.
- Монголын нөхцөлд ашиглаж болохуйц олон улсын сайн туршлагын жишээ.

# ЖМТ-ИЙН ҮНДСЭН ШИНЖ ЧАНАР

- ❑ Төрийн санхүүгийн удирдлага (Public Finance Management) болон Хөтөлбөрт суурилсан төсөвлөлт (Program Based Budgeting)-ийн шинэчлэлийн салшгүй нэг хэсэг.
- ❑ Гарцын чанарыг сайжруулах чиглэлд **аажмаар явагдах үйл явц**.
- ❑ Хууль эрх зүйн өөрчлөлтүүд, тодорхой бүтэц болон дагалдах журмуудыг ЖМТ-г нэвтрүүлэх үйл явцын туршид, аль болох нэн даруй боловсруулах нь чухал – СЯ, ЖҮХ-той хамтран журмуудыг явцын дунд боловсруулах.
- ❑ Бүх оролцогч талуудын (СЯ, ЖҮХ, Яамд, УИХ, Үндэсний статистикийн хороо, Олон улсын зөвлөх, ТББ) тодорхой үүргүүдийг томъёолж, чадавхийг хөгжүүлэх зорилтот хөтөлбөр боловсруулах – ажлын байран дээрх сургалт.
- ❑ Туршилтаар нэг эсхүл 2 Төсвийн захирагчийн 2021 оны төсвийн төлөвлөлтөд ЖМТ хийж, боломж, бэрхшээлүүдийг тодорхойлон дараагийн үе шатуудад туршилтаас сурсан зүйлсээ тусгах.
- ❑ Бусад улс орнуудын туршлага, ОУВС-ийн зөвлөмжийг хэрэгжүүлэх - өмнөх туршлагаас суралцах боломж.



# ЖМТ

Бүх салбарт  
байгаа жендэрийн  
ялгаатай байдлыг  
тодорхойлох



Ялгаатай байдлыг  
арилгах тодорхой  
арга хэмжээг  
санал болгох



Бодлогын тэргүүлэх  
чиглэл, үндсэн чиг  
үүрэг / бүрэн эрх,  
төсөвтэй уялдуулах




**Жендэрийн ялгаатай байдал**  
гэдэг нь нөөцийг ашиглах  
боломж, түүнийг хянах,  
түүнээс ашиг хүртэх зэрэгтэй  
холбоотой эрэгтэй, эмэгтэй  
хүмүүсийн хоорондын зөрүү  
буюу ялгаа юм.

Арга хэмжээний жишээ:

- **Нийгэм дэх харилцааг зохицуулах стандарт, дүрэм;**
- **Төсвийн чиглэлийн урамшуулал** (татаас, татвар гэх мэт) болон санхүүгийн болон санхүүгийн бус бусад арга хэмжээ;
- **Мэдээллийн, боловсролын** (мэдээлэл, боловсролын үйл ажиллагаа, бусад);
- **Институцийн, удирдлагын, зохион байгуулалтын** (шинээр байгуулах, одоо байгаа байгууллагыг татан буулгах, зарим байгууллагад зохион байгуулалтын өөрчлөлт хийх, ажилчдын тоо, чадавхийг өөрчлөх гэх мэт);
- **Төлөвлөлтийн үйл явцад оролцогчдын нийлүүлэх бараа, ажил үйлчилгээ.** (хөрөнгө оруулалтын болон дэд бүтцийн төсөл, хөрөнгө оруулалт гэх мэт)

# ЖМТ



# БАГЦ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Багц 1 – Урьдач  
нөхцөлийг хангах

Багц 2 –  
Туршилтаар 2021  
оны Төсвийн  
төлөвлөлтөд ЖМТ  
хийх

Багц 3 – Журам  
болон арга зүйг  
боловсруулах

Багц 4 –  
Чадавхийг  
бэхжүүлэх

Багц 5 –  
Харилцагч  
талуудын уялдаа  
холбоог хангах